

АВИЛГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

“Авилгатай тэмцэж шударга ёсыг тогтоон бэхжүүлэх нь”

Асуудал ба шийдэл

**Сэдэв: Албан тушаалын гэмт хэрэгт хамаарагсдын нийгмийн
хор аюул, тэднийг илрүүлэх нь**

Гүйцэтгэсэн: МУИС-ийн Хууль зүйн сургуулийн 5-р курсын оюутан Б.Эрдэнэмөнх

МУИС-ийн Хууль зүйн сургуулийн 4-р курсын оюутан Ж.Содномдаржаа

Улаанбаатар хот

2011 он

Албан тушаалын гэмт хэрэгт хамаарагсдын нийгмийн хор аюул, тэднийг илрүүлэх нь

1. Нийтлэг үндэслэл

1.1 Судалгааны зорилго:

Өнөөгийн нийгэмд тулгамдаад буй нэгэн асуудал болох авилгалын гэмт хэргийг бүрэн бодитоо бүх талаас нь илрүүлэх ба түүний дотор гэмт хэргийн хамаарагсдыг практикт илрүүлэхэд тулгарч буй асуудал, түүнийг шийдвэрлэх арга замыг нээн илрүүлэх зорилготой.

1.2 Судалгааны зорилт:

- Мөрдөн байцаагч, прокурор нарын Албан тушаалын гэмт хэргийн хамаарагсдыг илрүүлж байгаа эсэх
- Албан тушаалын гэмт хэрэгт хамаарагсад байх тохиолдол хэр элбэг тохиолддог талаар
- Илрүүлэх ажиллагаанд ямар ямар асуудал тулгарч байгаа талаар
- Шүүхийн шатанд албан тушаалын гэмт хэргийн хамаарагсдад эрүүгийн хариуцлага хүлээлгэж байгаа эсэх

1.3 Судалгааны шинэлэг тал:

Судалгаандаа практикт ажиллаж буй мөрдөн байцаагч, прокурор болон шүүхийн шийдвэрүүдэд судалгаа хийж Албан тушаалын гэмт хэргийн хамаарагсдыг илрүүлэх, эрүүгийн хариуцлага хүлээлгэх байдлыг судлан тогтоох бөгөөд энэ талаар өмнө судлагдаж байгаагүй тул судалгааны арга болоод судлагдахууны хувьд шинэлэг байна.

1.4 Судалгаа хийсэн арга зүй:


- Баримт бичгийн судалгаа
- Санал асуулга

2. Удиртгал

Монгол улсад хамгийн ихээр тулгамдаж буй бэрхшээлтэй асуудлуудыг жагсаан уу гэж асуухад ажилгүйдэл, ядуурал, авилга болон инфляци зэргийг


хамгийн олон дурьдсан байна.¹ Ноцтой асуудал гэж үзсэн оролцогчдын 10.1 хувь нь авилгал гэж үзсэн байна. Авилгал нь нийгмийн хамгийн хэцүү асуудлуудын нэг болох хувьд түүнтэй үр дүнтэй тэмцэх нь чухал асуудал юм. Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс 2011 онд хийсэн судалгаагаар Авилгалын гэмт хэргийн 30.1 хувь буюу 104 хэргийг прокурорт шилжүүлсэн, 24.9 хувь буюу 86 хэргийг хэрэгсэхгүй болгосон, 24.3 хувь буюу 84 хэргийг харъяаллын дагуу шилжүүлсэн, 2.3 хувь буюу 8 хэргийг түдгэлзүүлж, 11.0 хувь буюу 38 хэргийг бусад хэрэгт нэгтгэсэн байна.

Эдгээр хэргүүдэд хамаарагсад байдаг эсэх талаар Авилгалтай тэмцэх газрын мөрдөн байцаагч нар болон Прокурорын Ерөнхий газрын мөрдөн байцаагч, прокуроруудыг хамарсан нийт 10 хүнээс 5 асуулттай судалгаа явуулсан. Үүнд:




¹ Авилгалын төвшин тогтоох судалгаа. УБ.,2009. 5 дах тал.

Түүний дараа хэргийг эцэслэн шийдвэрлэх шат болох шүүхийн шатанд гэмт хэргийн хамаарагсдыг шийтгэж байгаа эсэхийг шалгавал. Албан тушаалын гэмт хэргийн шүүхийн шийдвэрийг (албан тушаалын гэмт хэргийн шүүхийн шийдвэрийн эмхэтгэл. Авилгатай тэмцэх газраас эмхлэн гаргасан судалгаа) 1, 2-д гарсан нийт 33 шүүхийн шийдвэр дээр судалгаа хийсэн. Үүнд:



Эрүүгийн хуулийн 268.1, 268.2, 264.2, 269.1, 150.3



Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 52.5, 59.1, 59.3, 49.2, 47.3, 57.1, 39.1

Дээрх судалгаануудаас сонирхолтой үр дүн гарсан ба Хэргийг илрүүлж шалгах шатанд буюу мөрдөн байцаах, прокурорын шатанд судалгаанд оролцогчдын 70% нь Албан тушаалын гэмт хэргийн хамаарагсдыг илрүүлж байсан буюу хоёр гэмт хэргийн нэгд хамаарагсад эсхүл зарим гэмт хэрэгт хамаарагсад тохиолддог гэсэн хариулт өгсөн байдаг. Гэтэл шүүхийн шийдвэрт анализ хийж үзэхэд Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 39 дүгээр зүйлийг журамлан ял оногдуулсан буюу Албан тушаалын гэмт хэргийн хамаарагсад эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн тохиолдол байгаагүй юм.

3. Судалгааны онолын үзэл баримтлал

3.1 Эрүүгийн хуулийн хамаарагсдын тухай ойлголт, тэдний нийгмийн хор аюул

Олон хүн эрсдэлтэй зүйлийг хийхэд хүрвэл эрсдэл ихсэх тусам хамтын хүчээр түүнийг давхийг эрмэлздэг.² Албан тушаалын гэмт хэрэгт ч мөн адил эрсдэлийг давхийг тулд хүчээ нэгтгэх боломжтой. Гэмт хэргийн хамаарагсад нь урьдчилан амлалгүйгээр хүчээ нэгтгэдгээрээ онцлогтой.

Гэмт хэргийн хамаарагсад гэдэг нь үйлдэхээр бэлтгэгдэж байгаа болон нэгэнт үйлдэж дууссан гэмт хэрэгтэй холбогдож байгаа боловч тэдгээрт оролцоогүй, тодорхой этгээд Эрүүгийн хуулийн Тусгай ангид нэрлэж заасан хүнд, онц хүнд гэмт хэргүүдийг үйлдэхээр бэлтгэж байгааг буюу үйлдсэнийг лавтай сайн мэдэж байгаад зохих байгууллага буюу албан тушаалтанд санаатай мэдэгдээгүй, гэмт хэрэг үйлдсэн этгээд, гэмт хэрэг үйлдэхэд хэрэглэсэн зэвсэг, хэрэгсэл, гэмт хэргийн ул мөр, гэмт хэрэг үйлдэж олсон эд зүйлийг урьдчилан амлалгүйгээр санаатай нуун далдалсан, эсхүл албан тушаалын эрх мэдэл, үүрэгт хамаарах үйл ажиллагааг хийгээгүй, хэрэг хариуцах чадвартай, субъектын насанд хүрсэн хувь хүмүүс юм.³

Нуун далдлах болон үл мэдээлэх нь хууль сахиулах байгууллагын ажилд ихээхэн хүндрэл учруулдаг. Гэмт хэрэгтнийг нуун далдлах нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийг /гүйцэтгэгч болон бусад хамтран оролцогчид/ орон байр, хувцас, баримт бичиг, тээврийн хэрэгсэл зэргээр хангах замаар нуух явдлаар илэрнэ. Гэмт хэргийг нуун далдлах нь гэмт хэрэг үйлдэхэд хэрэглэсэн зэвсэг, хэрэгсэл, гэмт хэргийн ул мөр, гэмт хэргийн нотлох баримтыг илрүүлэх явдалд бүхий л боломжтой арга замаар саад учруулснаар илэрнэ.⁴ Нуун далдлагч нь гэмт хэргийн оролцогч болох хамжигчаас урьдчилан үгсэн тохиролцоогүй байдаг шинжээрээ ялгагдана.

Эрүүгийн хуулийн Хууль ёсны зарчмаар аливаа үйлдэл, эс үйлдхүйг гэмт хэрэгт тооцох, түүнд оногдуулах ял, эрүүгийн хариуцлага ... хүлээлгэх агуулга бүхий зарчмын дагуу, хэргийн нөхцөл байдлыг тал бүрээс нь бүрэн бодитой тогтоохын тулд хамаарагсдыг илрүүлэх, тэдэнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх нь хуульд зааснаар болоод онолын хувьд гарцаагүй юм. Нуун далдлах, үл мэдээлэх нь нийгэмд авилга, хээл хахууль илрэхгүй бугших, илрүүлэх ажиллагаанд ихээхэн

² Чезаре Беккари. Гэмт хэрэг ялын тухай. УБ. 2009 онд орчуулсан. 108 дах тал.

³ УДШ-ээс гаргасан. Эрүүгийн хуулийн тайлбар. УБ., 2010. 124 дах тал.

⁴ С.Нарангэрэл. Монгол Улсын эрүүгийн эрх зүй. УБ., 1999. 250 дах тал.


саад болох, тухайн гэмт хэрэгт шууд шалтгаант холбоогүй ч түүний эс үйлдэхүй нь том гэм буруу, хор уршиг дагуулдаг байна.

3.2 Албан тушаалын гэмт хэрэгт хамаарагсдыг илрүүлэх, мөрдөн шалгах ажиллагаа

Энэ хэсэгт албан тушаалын зарим гэмт хэргийг илрүүлэх ажиллагаа, тактик, арга барилын талаар авч үзнэ.

Авилгалын арга олон янз бөгөөд төрийн байгууллагын орчин, түвшингээс шалтгаалах бөгөөд ямагт, хувийн буюу бүлгийн өндөр ашигт хүрэхэд чиглэсэн, чадварлагаар нууцлагдсан байдаг. Зөвхөн хууль хамгаалах байгууллагын зүгээс хэрэг бүртгэх, мөрдөн байцаахад хамгийн идэвхтэй үйл ажиллагаа явуулахын чухлыг нотлоод зогсохгүй, ийм хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт хүнд байдаг байна. Гэсэн ч гэмт хэргийн криминалистикийн шинжийн тухай мэдлэг, криминалистикийн арга зүйг эзэмшсэн байх нь түүнийг амжилттайгаар бүртгэх байцаах бололцоо олгоно.⁵

Авилгалтай тэмцэх газрын мөрдөн байцаагчид болон Прокурорын Ерөнхий газрын мөрдөн байцаагч, прокуроруудыг хамарсан судалгаанаас үзэхэд



Дээрх байдлуудаас үзвэл авилгын гэмт хэрэг тэр дундаа хамаарагсдыг илрүүлэх нь төвөгтэй, хэцүү болох нь харагдаж байна. Иймд доор илрүүлэх арга ажиллагааны талаар онолын үзэл баримтлал дэвшүүлж байна.

Хээл хахуулийн гэмт хэргийн нотлогдвол зохих байдал:⁶

⁵ Криминалистик II. Жамбалын Хурцгэрэл. УБ., 2004 он. 530 дугаар тал.

⁶ Судалгааны ажилтай холбогдуулан холбогдох хэсгийг түүвэрлэн оруулав.

1. Хахууль өгсөн, нуусан арга
2. Гэмт хэрэгт оролцогчдын хоорондын харилцааны тус бүрийн үүрэг
3. Гэмт хэрэгт оролцогч бүрийг тогтоох
4. Гэмт хэрэг үйлдэхэд бололцоо олгосон нөхцөл байдал зэрэг болно.

Мөн дараах арга, тактик ашиглаж албан тушаалын гэмт хэргийн хамаарагсдыг илрүүлэх нь зүйтэй:⁷

Хэрэв мэдээлэлд хахууль өгөгчийг заагаагүй бол түүнийг тогтоох, мэдээлэгчийн хувийн байдал, тэрээр хээл хахууль өгөгч, авагчтай ямар харилцаатайг тодруулах арга хэмжээ авна.

Мөрдөн байцаалт төлөвлөхдөө хээл хахууль авсныг шууд буюу шууд бусаар нотлох тийм баримтыг юуны өмнө тогтоохыг чухалчлах хэрэгтэй: ... г) дээр дурдсан үйл явдлыг харсан хүнийг олж тогтоох.

Хээл хахууль хэзээний өгсөн этгээдийг байцаахдаа дараах байдлыг тогтооно: ... хээл хахууль өгсөн тухайгаа хэнд ярьсан, хээл хахууль авсан, өгсөн тухай хэн шууд болон шууд бусаар мэдэх. Хэрэв байцаагдагч хөндлөнгийн хүн байвал юуны өмнө хахуулийн талаар хаанаас мэдсэн, чухам юу, хээл хахууль өгч байгааг хаанаас харсан эсэх, юуны учир өгсөн, энэ үйлдлээ хийсэн эсэх, хээл хахууль авсан, өгсөн тухай өөр хэн мэдэхийг тодруулна.

Дээрх арга, ажиллагаагаар албан тушаалын гэмт хэрэгт оролцогчдоос гадна хамаарагсдыг олж тогтоох нь зүйтэй байна. Мөн хэн, ямар этгээд хамаарагсад байж болох талаар судалгаа явуулж, таамаглал дэвшүүлэх, судалгаа, таамаглалын үндсэн дээр мөрдөн шалгах илрүүлэх ажиллагааг эхлэх хэрэгтэй.

Авилгалтай тэмцэх газрын мөрдөн байцаагчид болон Прокурорын Ерөнхий газрын мөрдөн байцаагч, прокуроруудыг хамарсан судалгаанаас үзэхэд

⁷ Криминалистик II. Жамбалын Хурцгэрэл. УБ., 2004 он. 521-529-р тал

Албан тушаалын гэмт хэргийн хамаарагсдаар ихэвчлэн ямар субъект байх магадлалтай вэ?

- Албан тушаалын гэмт хэрэгтний туслах
- Шууд удирдлаганд нь ажилдаг албан тушаалтан
- Энгийн иргэн




Судалгаанаас үзвэл ойр дотно ажилладаг этгээдүүд хамаарагсад байх магадлал өндөр байна. Онолын хувьд гэм хэргийн хамаарагсдаар ойрын төрөл садан, тухайлбал, эцэг эх, үр хүүхэд, үрчлэгч, үрчлэгдэгч, төрсөн ах, эгч дүүс, өвөг, эцэг, эмэг эх, ач нарын хувьд эрүүгийн хариуцлагад татах шаардлагагүй. Ийм өөрчлөлтийг бидний үзэж байгаагаар эрүүгийн хуульд оруулах нь зүйтэй. Энэ нь Монгол улсын Үндсэн хуульд заасан “гэр бүлийн гишүүд эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх” эрхээс үүсэлтэй.⁸

Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулийн 16.1. “Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх нь хэргийн байдлыг тал бүрээс нь бүрэн бодитойгоор нотлохын тулд хуульд заасан бүх арга хэмжээг авч” ... ажиллах үүрэгтэй гэж заасны дагуу албан тушаалын гэмт хэргийн оролцогчдыг илрүүлэн шалгаж, эрүүгийн хариуцлага хүлээлгэх нь авилгатай тэмцэхэд ихээхэн ач холбогдолтой гэж үзэж байна.

Авилгалтай тэмцэх газрын мөрдөн байцаагчид болон Прокурорын Ерөнхий газрын мөрдөн байцаагч, прокуроруудыг хамарсан судалгаанаас үзэхэд илрүүлэх шаардлага зайлшгүй байна гэдгийг давхар нотлож байна.

Албан тушаалын гэмт хэрэгт хамаарагсдыг илрүүлэх зайлшгүй шаардлага байгаа юу?



⁸ Монгол улсын эрүүгийн эрх зүйн ерөнхий анги. С.Нарангэрэл. УБ., 1999 он. 251-р тал.

Эрх зүйн орчны судалгаа

Гэмт хэргийг үл мэдээлэгчид Эрүүгийн хуулийн 39.4-р эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан ч Авилгалын эсрэг хуулийн 8.1-т тодорхойлсон албан тушаалтан нь АЭХ-ийн 8.3-т зааснаар энэ хуулийн 8.1-д заасныг зөрчсөн албан тушаалтныг 200000-250000 төгрөгөөр торгоно гэсэн байна. Тиймээс АЭХ-ийн Авлигийн тухай мэдэгдэх үүрэг хүлээсэн этгээдүүд болон эрүүгийн хуульд заасан үл мэдээлэгчийн хооронд ямар ялгаа байгаа эсхийг судлан тогтоох шаардлагатай.

Үл мэдээлэх нь тухайн субъект Эрүүгийн хуулийн 246 дугаар зүйлд нэрэлж заасан хүнд, онц хүнд гэмт хэргийг үйлдхээр бэлтгэсэн, үйлдсэнийг лавтай сайн мэдсэн, энэ талаар бүрэн мэдлэг, итгэлтэй болсон байх, Эрүүгийн хуулийн 264 дүгээр зүйлд заасан гэмт хэргүүдийг үйлдсэнийг зохих байгууллага, албан тушаалтанд мэдээлээгүй байх, энэ гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж байгаа, эсхүл үйлдэж дууссаныг үл мэдээлсэн байх зэрэг шинжүүд байна.⁹

Гэмт хэргийн талаар лавтай сайн мэдсэн байх гэдэг нь үйлдэхээр бэлтгэж байгаа буюу үйлдсэн гэмт хэргийн тухай ямар ч эргэлзээгүй, баттай мэдээ авч, түүнийгээ батлах хангалттай баримттай болсон тохиолдол юм.

Харин АЭХ-ийн 8.1.Дараах албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэх явцдаа олж мэдсэн авлигын талаархи мэдээллийг нэн даруй Авлигатай тэмцэх газарт мэдэгдэх үүрэгтэй: 8.1.1.шүүгч; 8.1.2.прокурор 8.1.3.цагдаа, тагнуулын байгууллагын албан тушаалтан; 8.1.4.төрийн аудитын болон мэргэжлийн хяналтын байгууллагын албан тушаалтан, 8.1.5.төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллагын албан тушаалтан.

8.3.Энэ хуулийн 8.1-д заасныг зөрчсөн албан тушаалтныг 200000-250000 төгрөгөөр торгоно.¹⁰ Гэж зааснаас үзвэл “албан үүргээ гүйцэтгэх явцдаа олж мэдсэн авилгын талаархи мэдээлэл” гэдгийг хэрхэн ойлгох нь тодорхойгүй байгаа юм. Энэ тодорхойгүй байдлаас гэм хэрэгтнүүд зөвхөн захиргааны хариуцлага, торгууль төлсөн төдийхнөөр эрүүгийн хариуцлагаас мултарч ял завших боломжыг олгосон гэж үзэхээр байна.

⁹ УДШ-ээс гаргасан. Эрүүгийн хуулийн тайлбар. УБ., 2010. 124 дах тал.

¹⁰ Авлигалын эсрэг хуулиас

Албан тушаалын гэмт хэрэгт хамаарагсдыг илрүүлэх, тэдэнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх ажиллагаа эрчимжсэнээр эерэг үр дагавар байхын зэрэгцээ сөрөг үр дагавар гарах магадлалтай. Жишээ нь хэлсдүүлэх, Үндсэн хуульд заасан эрхийг зөрчих зэрэг. Иймд дараах хязгаарыг тавих хэрэгтэй. Онолын хувьд гэм хэргийн хамаарагсдаар ойрын төрөл садан, тухайлбал, эцэг эх, үр хүүхэд, үрчлэгч, үрчлэгдэгч, төрсөн ах, эгч дүүс, өвөг, эцэг, эмэг эх, ач нарын хувьд эрүүгийн хариуцлагад татах шаардлагагүй. Ийм өөрчлөлтийг бидний үзэж байгаагаар эрүүгийн хуульд оруулах нь зүйтэй. Энэ нь Монгол улсын Үндсэн хуульд заасан “гэр бүлийн гишүүд эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх” эрхээс үүсэлтэй.¹¹ /Үндсэн хуулийн 16.14/ Хэлэсдүүлэхгүй байх нь мөрдөн байцаах ажиллагаанаас хамааралтай асуудал байна.

4. Дүгнэлт, санал

Дээрх судалгааны ажлаа товчхон дүгнэж хэлэхэд авилгатай тэмцэхэд тэрхүү гэмт хэргийн хамаарагсад саад тотгор учруулж байгааг тогтоосон бөгөөд тэдний нийгмийн хор аюул, гэм буруугын хэр хэмжээ нь их байдгийг харуулж, тэднийг илрүүлэх, эрүүг хариуцлага хүлээлгэх зарим арга, тактикийг судалж, шийдвэрлэх арга замыг эрэлхийллээ.

Судалгааны ажилтайгаа холбогдуулан, Авилгатай тэмцэхэд дараах санал ач холбогдолтой гэж үзэж байна.

1. Авилгын гэмт хэрэгт хамаарагсад хэн, ямар этгээд байж болох талаар гэмт хэрэг тус бүрт нарийн судалгаа явуулах

2. Өгүүлэн буй гэмт хэргийг илрүүлэх /хамаарагсдыг/ онцлог, арга, тактикийг мөрдөн байцаагч, прокуроруудад сургалтаар таниулж, тэдний үйл ажиллагааг идэвхжүүлэх

3. Авилгын эсрэг хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдээлэл өгөхийг Эрүүгийн хуулийн үл мэдээлэгчээс ялгах. Өөрөөр хэлбэл албан үүргээ гүйцэтгэх явцдаа олж мэдсэн авилгын талаарх мэдээлэл гэдгийг Эрүүгийн хуульд заасан үл мэдээлэх үйлдэлээс ялган тодорхойлох

4. Гэмт хэрэгт хамаарагсдыг хавтгайруулан хариуцлага тооцохоос сэргийлж Монгол улсын Үндсэн хуульд заасан “гэр бүлийн гишүүд эцэг эх, үр

¹¹ Монгол улсын эрүүгийн эрх зүйн ерөнхий анги. С.Нарангэрэл. УБ., 1999 он. 251-р тал.

хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх” зарчимд нийцүүлэн Эрүүгийн хуульд холбогдох зохицуулалтыг нэмж өөрчлөх.

5. Эх сурвалж

Ном, зохиол

1. Монгол улсын эрүүгийн эрх зүйн ерөнхий анги. С.Нарангэрэл. УБ., 1999 он.
2. УДШ-ээс гаргасан. Эрүүгийн хуулийн тайлбар. УБ., 2010.
3. Криминалистик II. Жамбалын Хурцгэрэл. УБ., 2004 он.
4. Чезаре Беккари. Гэмт хэрэг ялын тухай. УБ. 2009 онд орчуулсан.
5. Криминалистик. /Онол арга зүйн хураангуй тайлбар/ Б.Дашзэвэг. УБ., 2010 он.
6. Илрээгүй гэмт хэргийг илрүүлэх ажиллагаа. Ж.Болдбаатар. УБ., 1999 он.

Хууль, эрх зүйн акт

1. Монгол улсын Үндсэн хууль
2. Эрүүгийн байцаан шийтгэх хууль
3. Эрүүгийн хууль
4. Авилгын эсрэг хууль
5. Улсын дээд шүүхийн тайлбараас

Бусад

1. Судлаачийн хувийн судалгаа
2. Авилгатай тэмцэх газраас эрхлэн гаргасан “Албан тушаалын гэмт хэргийн шүүхийн шийдвэрийн эмхтгэл” I, II
3. Бусад интернэт сайтуудын судалгаа, мэдээлэл

Агуулга

1. Нийтлэг үндэслэл
2. Удиртгал
3. Судалгааны онолын үзэл баримтлал
4. Эрх зүйн орчны судалгаа
5. Дүгнэлт, санал
6. Эх сурвалж